



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2017 оны 11 сарын 28 өдөр

Дугаар 98

Арвайхээр

Г

Г

Хөтөлбөр батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 "ж", 20 дугаар зүйлийн 20.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Өвөрхангай аймгийн Эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэх хөтөлбөр" /2017-2024 он/-ийг хавсралтаар баталсугай.

2. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх цаг хугацааны нарийвчилсан төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, шаардлагатай хөрөнгийг аймгийн жил бүрийн төсөвт тусгаж ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Ганболд/-д даалгасугай.

3. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бүхий л талаар хамтарч ажиллахыг аймгийн нийт төрийн болон төрийн бус байгууллага, иргэдэд уриалсугай.

ДАРГА



А.ИШДОРЖ

аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2017 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн
98 дугаар тогтоолын хавсралт

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙГ
ЭРЧИМЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР**

/2017-2024 он/

Нэг. Зорилго, хүрэх үр дүн

1. Зорилго: Бүсийн болон олон улсын зах зээлд нэвтрэх замаар аймгийн эдийн засгийг тэлнэ.

2. Хүрэх үр дүн: Ажилгүйдлийн түвшинг гарааны үзүүлэлт 9,8 хувийг 2024 он гэхэд 8,5 хувь болгож бууруулна.

Хоёр. нийтлэг үндэслэл, эдийн засгийн өнөөгийн байдал

Хөрөнгө оруулалт; 2016 онд аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд 26.9 тэрбум төгрөгний хөрөнгө оруулалт хийгдсэнээс 28.1 хувь буюу 7.6 тэрбум төгрөг нь улсын төсвийн хөрөнгө оруулалт, 16.2 хувь буюу 4.4 тэрбум төгрөг нь орон нутгийн төсөв болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр, 1.3 хувь буюу 0.3 тэрбум төгрөг нь гадаадын хөрөнгө оруулалт, 54.4 хувь буюу 14.6 тэрбум төгрөгний хөрөнгө оруулалт нь иргэдийн хөрөнгөөр тус тус санхүүжигдсэн байна. 2015 онтой харьцуулахад хөрөнгө оруулалтын хэмжээ 32.7 хувь буюу 13.1 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Дотоодын нийт бүтээгдэхүүн; аймгийн эдийн засгийг 2014-2024 онд хөгжүүлэх бодлогын баримт бичигт 2015 он гэхэд 424.0-458.0 тэрбум төгрөг, 2018 он гэхэд 689.0-834.0 тэрбум төгрөг, 2021 он гэхэд 1019.0 их наяд төгрөгт хүрэх зорилтыг тавьсан. 2016 оны байдлаар аймгийн ДНБ бүтээгдэхүүн 450.8 тэрбум төгрөг байна.

2016 оны аймгийн нийт хүн амын 63.4 хувь буюу 72233 нь хөдөлмөрийн насны хүн ам байгаа нь өмнөх оныхоос 294 хүнээр буюу 0.4 хувиар өссөн байна. Хөдөлмөрийн хэлтэст 2482 хүн ажил хайгч бүртгүүлсэний 54.2 хувь нь эмэгтэйчүүд байна. Бүртгүүлсэн ажилгүйчүүд өнгөрсөн онтой харьцуулахад 21.2 хувиар өссөн байна.

Гурав. Зорилт, үйл ажиллагаа

Зорилт-1.Хөдөө аж ахуйг хөгжүүлж, орон нутгийн түүхий эдэд суурилсан, гадаад зах зээлд түшиглэсэн жижиг, дунд үйлдвэрүүдийг байгуулах.

Үйл ажиллагаа:

1. Махны үйлдвэр байгуулах.
2. Дайвар бүтээгдэхүүний үйлдвэр байгуулах.
3. Арьс ширний үйлдвэр байгуулах.
4. Үслэг эдлэлийн үйлдвэр байгуулах.
5. Ноосон бүтээгдэхүүний үйлдвэр байгуулах.
6. Бордооны үйлдвэр байгуулах.
7. Ясны үйлдвэр байгуулах.
8. Оёдол, ээрмэл, сүлжмэл, нэхмэлийн үйлдвэрүүд байгуулах.
9. Чацарганы үйлдвэр байгуулах.
10. Гоёоны үйлдвэр байгуулах.
11. Цавууны үйлдвэр байгуулах
12. Борцны үйлдвэр байгуулах.
13. Сүү, цагаан идээний үйлдвэр байгуулах.
14. Боржин чулууны үлдвэр байгуулах.
15. Гурил, тэжээлийн үйлдвэр байгуулах.
16. Арьс ширний чиглэлийн ферм байгуулах.
17. Махны чиглэлийн фермүүдийг байгуулах.
18. Хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр байгуулах
- 19.Барилгын материалын үйлдвэрлэл хөгжүүлэх. /тоосго, бетон, вааран черепиц, шохой, цементийн нэмэлт, хүрмэн бетон блок, өнгөлгөөний чулуу/

Хүрэх үр дүн: Ажлын байр нэмэгдэж, орон нутгийн болон аж ахуйн нэгжүүдийн орлого нэмэгдсэн байна.

Зорилт-2. Үйлдвэрлэл, хөдөө аж ахуйг хөгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

1. Үйлдвэрлэл, бүтээгдэхүүн борлуулалт, зуучлал, тээвэр ложистикий төрөлжүүлж, кластер хэлбэрээр хөгжүүлэх.
2. Аймгийн Бизнес, эдийн засгийн зөвлөлдөх хорооны үйл ажиллагааг идэвхижүүлэх.

3. Орон нутагт үйлдвэрлэгдсэн бараа, бүтээгдэхүүнийг төрийн худалдан авалтад нэн түрүүн шалгаруулдаг байх хуулийн заалтыг мөрдөж ажиллах.
4. Зарим томоохон сумдыг үйлдвэрийн районтон болгож, дэд бүтцийг шийдвэрлэх.
5. Үйлдвэрлэл эрхлэгчдийн зөвлөгөөнийг тогтмол зохион байгуулж хэвших.
6. Ерөнхий боловсролын зарим сургуулиудыг ХААИС болон ШУТИС-ийн харьяа лицей сургуулийн хэлбэрээр хөгжүүлэх боломжийг судлан хэрэгжүүлэх.
7. Сумдад хөрөнгө оруулалтыг татах ажлыг сумдын удирдлагуудтай хамтран зохион байгуулах
8. Мал эрүүлжүүлэх, бордох бүсийг байгуулж, эдийн засгийн эргэлтэд оруулах.
9. Малын хашаа, саравчийг шинэ төрлийн материалаар хийх бололцоог судлан, хэрэгжүүлэх.
10. Мал аж ахуйн үйлдвэрлэлд гар ажиллагааг хөнгөвчилсөн техник, технологи нэвтрүүлэх.
11. Усллагаатай тариалан, автоматжсан зоориудыг бий болгох.
12. Атаршсан газруудыг эргэлтэд оруулж, эрт ургацын сортын тариалалтыг хөгжүүлэх.
13. Тодорхой бизнесүүдийг төсөлжүүлж, гадаадын хөрөнгө оруулагчтай холбож өгөх.
14. Олон улсын үзэсгэлэн худалдаанд 1-4 иргэн, ААНБайгууллагыг тогтмол оролцуулж, мэдээллийн нэгдмэл баазтай болох.
15. Хөрөнгө оруулалтын чуулга уулзалтуудыг тогтмол зохион байгуулах.
16. Аймгийн брэнд бүтээгдэхүүнийг гаргаж, бүх талаар дэмжих.

Хүрэх үр дүн: Бизнесийн таатай орчин бүрдүүлж, сурталчилах замаар үйлдвэрлэлийг хөгжүүлж, орон нутгийг төлөөлж чадахуйц нутгийн брэнд бүтээгдэхүүнтэй болсон байна.

Зорилт-3. Орон нутгийн өмчит компаниудыг үр ашигтай ажиллуулах.

1. "Онги Ус суваг" ХХК-ний үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй болгож, үр ашгийг нь нэмэгдүүлж, хуримтлалыг аймгийн Үйлвэрлэл, технологийн санд төвлөрүүлэх.

2. Богд суманд “Богд-Ус суваг” ХХК-ийг бие даалган байгуулж, үр ашигтай ажиллуулах.
3. “Хархорин ус суваг” ХХК-ний үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй болгож, үр ашгийг нь нэмэгдүүлж, хуримтлалыг аймгийн Үйлвэрлэл, технологийн санд төвлөрүүлэх.
4. “Баянтээг” ХК-нийг үр ашигтай ажиллуулж, хуримтлалыг аймгийн Үйлвэрлэл, технологийн санд төвлөрүүлэх.
5. “Хужирт рашаан шавар” улсын үйлдвэрийн газрыг үр ашигтай ажиллуулж, хуримтлалыг аймгийн Үйлдвэрлэл, технологийн санд төвлөрүүлэх.
6. Махны үйлдвэрийн бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд борлуулах замаар үр ашгийг нэмэгдүүлж, хуримтлалыг аймгийн Үйлвэрлэл, технологийн санд төвлөрүүлэх.
7. Орон нутгийн өмчийн оролцоотой, гадаадын хөрөнгө оруулалттай хайгуулын компанийг байгуулж, үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах.

Хүрэх үр дүн: Орон нутгийн өмчит компаниудын үр ашгаас бусад үйлдвэрүүдийг шинэ тутам байгуулах үйл ажиллагаа хэвшсэн байна.

Зорилт-4. Аялал жуулчлалыг шинэ түвшинд хөгжүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

1. Говийн болон зүүн, баруун бүсийн аялал жуулчлалын томоохон маршрутыг шинээр бий болгох.
2. Орхон голын эко системийн төлбөр авах, зарцуулах үйл ажиллагааг нэвтрүүлэх.
3. “Торгоны зам ба Хархорум хот”, “Эсгийний баяр”, “Сарлагийн баяр”, “Тэмээний баяр”, “Адууны баяр” зэрэг аялал жуулчлалын арга хэмжээг жил бүр зохион байгуулж, үйл ажиллагааны хүрээг өргөтгөх.
4. “Аймгийн баяр наадам” аялал жуулчлалын арга хэмжээг зохион байгуулж хэвших.
5. Эрдэнэ зуу, Төвхөн, Хүрхрээ орчмуудын угтах орчныг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх.
6. Аялал, жуулчлалын мэдээллийн төвийг Арвайхээрт байгуулж, түүний салбар нэгжийг Хархорин, Бүрд сумдад байгуулах.

7. Аймагт аялал жуулчлалын кластерын зураглал гаргаж, түүнийг хэрэгжүүлэх.

Хүрэх үр дүн: Гадаадын болон дотоодын жуулчдын жилийн суурь тоо 45,000-ыг 90,000-д хүргэж, аялал жуулчлалаас олох иргэдийн орлогыг нэмэгдүүлсэн байна.

Зорилт-5. Байгаль орчинд ээлтэй уул уурхайг хөгжүүлнэ.

1. Аймгийн нутаг дэвсгэрт буй ашигт малтмалын илэрцүүдийг нээлттэй судлуулах ажил зохион байгуулах.
2. "Баянтээг" ХК-ний эзэмшлийн талбайн орчимд нүүрсний нөөц нэмэгдүүлэх хайгуулын арга хэмжээ авч, лиценз эзэмшигч бусад компаниудтай хамтарч ажиллах.
3. "Баянтээг" ХК-ний нүүрсийг Улаанбаатар хот болон гадаадын зах зээлд нийлүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх.
4. "Баянтээг" ХК-ний дэргэд нүүрс боловсруулах үйлдвэр байгуулах.
5. Баян-Өндөр суманд буй нүүрсний илэрцийг эдийн засгийн эргэлтэд оруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх.
6. Төгрөг, Гучин-Ус сумд дахь нефтийн хайгуулын ажлыг орон нутгаас дэмжиж ажиллах.
7. Хайгуул, ашиглалт явуулагч компаниудтай нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж, аймгийн Үйлдвэрлэл технологийн санд хөрөнгө хуримтлуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх.
8. Бичил уурхайг нөхөрлөл, хоршооны зохион байгуулалтанд оруулах замаар хөгжүүлж ажлын байр бий болгох.
9. Уул уурхайн үйлдвэрлэлд туслах хэрэглэгдэхүүний үйлдвэрлэлийг түншлэлийн зарчмаар бий болгож ажлын хувцас, хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлтийг 100 хувь орон нутгаас нийлүүлдэг болох.
10. Мод тарих "Ногоон хэрэм" үйл ажиллагааг өргөнөөр зохион байгуулах.

Хүрэх үр дүн: Уул уурхай хөгжиж, түүнийг дагасан бусад бизнесүүд хөгжсөн байна.

Зорилт-6. Худалдаа үйлчилгээний салбарыг шинэ шатанд гаргаж хөгжүүлнэ.

1. Аймгийн төвд баруун бүсийн худалдаа, үйлчилгээний бөөний төвийг байгуулах.
2. Үндэсний хэмжээний худалдааны сүлжээ компаниудын салбарыг орон нутагт нэвтрүүлэх.

3. Малчдын гар ажиллагааг хөнгөвчлөх тоног төхөөрөмжүүдийн хэрэглээг нэвтрүүлэх.
4. Оюутолгой, Тавантолгойгэхмэттомоохонгазартборлуулалтхийх.
5. Шивээ хүрэн, Цагаан дэл, Эрээн, Алтан булгийн боомтуудад худалдаа эрхлэгчдийн төлөөлөгчдийг тогтмол ажиллуулах.
6. Зочид буудлын сүлжээ компаний үйл ажиллагааг орон нутагт нэвтрүүлэх.
7. Авто засварын сүлжээ компаний үйл ажиллагааг орон нутагт нэвтрүүлэх.
8. Түргэн хоолны сүлжээ компаний үйл ажиллагааг орон нутагт нэвтрүүлэх.
9. Эмнэлэгийн үйл ажиллагаа эрхэлдэг компаний үйл ажиллагааг орон нутагт нэвтрүүлэх.
10. Боловсролын үйл ажиллагаа эрхэлдэг компаний үйл ажиллагааг орон нутагт нэвтрүүлэх.
11. Орон нутагт их, дээд сургуулийн салбарыг нээн ажиллуулах арга хэмжээ авах.

Хүрэх үр дүн: Худалдаа, үйлчилгээний салбарт зэрэглэл өндөр, боловсон үйлчилгээ нэвтэрсэн байна.

Зорилт- 7. Дэд бүтэц, тээвэр ложистикийн цогц шийдэл бий болгоно.

1. Бүх сумдыг инженерийн шугам сүлжээтэй болгох.
2. Арвайхээрт дулааны цахилгаан станц байгуулж, ажиллуулах замаар гэр хорооллыг бууруулах.
3. Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч нарт газрыг шуурхай шийвэрлэх зарчмыг мөрдүүлэх.
4. Тээвэр ложистикийн баруун бүсийн төвийг Арвайхээрт байгуулах.
5. Өмнөговь аймгийн Даланзадгад сум, Цагаан дэл, Шивээ хүрэнгийн боомтууд хүртэл засмал зам тавих ажлыг эхлүүлэх арга хэмжээ авах.
6. Хужирт, Бүрд, Есөнзүйл, Өлзийт, Тарагт, Уянга, Хайрхандулаан сумдын төвүүдийг улсын чанартай автозамд засмал зам тавьж холбох.
7. Хөдөө аж ахуйн бэлтгэл, бөөний ба жижиглэнгийн худалдаа, зорчигч тээвэр, аялал жуулчлал, барилга, уул уурхайн ложистикийн цогц үйлчилгээг бий болгох.
8. Нар, салхи, газрын гүний үүсгэлтэй эрчим хүчний эх үүсвэрүүдийг байгуулах.

Хүрэх үр дүн: Засмал замууд нэмэгдэж, тээврийн үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болсон байна.

Зорилт – 8. Гадаад харилцааг эдийн засагжуулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

1. Аймгийн гадаад харилцааг нэгдсэн нэг бодлогод хамруулах.
2. Уламжлалт харилцаат Франц, Итали, Солонгосын харилцааг үргэлжлүүлж, шинэ шатанд гаргах.
3. БНХАУ-ын Гүй жөү, Ниншя, Шандон мужууд, Алша аймаг, ОХУ-ын Эрхүү мужтай харилцаа тогтоож, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх.
4. Энх тайван найрамдлын байгууллагын салбарыг аймагт байгуулж, гадаад орнуудтай найрсаг хамтын ажиллагааг хөгжүүлэх.
5. Гадаадын хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөлийг аймагт байгуулах.

Хүрэх үр дүн: Гадаад харилцаанаас эдийн засгийн өсөлтөд оруулах хувь нэмрийг ахиулсан байна.

Зорилт – 9. Санхүү, бизнесийн тогтолцоог сайжруулах цогц арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

1. Банкны зээл, санхүүгийн үйл ажиллагаанд орчин үеийн шийдлийг нэвтрүүлж, үнэт цаас, санхүүгийн зах зээлд бизнес эрхлэгчдийг нэмэгдүүлэх.
2. Аймгийн орон нутгийн өмчит компаниуд болон томоохон хадгаламж эзэмшигчид, гадаадын хөрөнгө оруулагчдын нэгдлийн үндсэн дээр "Аймгийн бизнес санхүүгийн корпораци" байгуулах.
3. Аймагт Үйлдвэрлэл-технологийн сан байгуулж ажиллуулах./Аймгийн Бизнес, санхүүгийн корпорацийн дэргэд/
4. Аймагт томоохон лаборатори байгуулж, түүнд тулгуурласан хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, технологийн парк байгуулах.
5. Бизнес эрхлэгч нарт хэрэгцээт статистик мэдээллийг гаргаж хэвших.
6. Аймгийн бизнесийн зөвлөгөө, мэдээллийн төвийг байгуулж ажиллуулах замаар сумдын бизнес хөгжлийн төвүүдийн үйл ажиллагааг шинэтгэн зохион байгуулах.
7. Аймгийн Бизнесийн зөвлөгөө, мэдээллийн төвөөр боруулалт, зуучлалын үйл ажиллагааг оновчтой явуулж, үндэсний томоохон компаниуд болон гадаадын орон, чөлөөт бүсүүдэд худалдааны төлөөлөгчдийг ажиллуулах.
8. Аймгийн Эдийн засгийн төлөөллийн итгэмжлэлийг зарим төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудад олгож, гадаадын муж, байгууллагуудтай хамтарч ажиллах.

9. Сумдын эдийн засгийн тэргүүлэх чиглэл болон аймгийн эдийн засгийн хөгжлийн бодлогыг уялдуулж хөгжүүлэх.
10. Үнэт цаасны зах зээлийн арилжаанд оролцох үйл ажиллагааг идэвхижүүлэх.
11. Аймгийн ИТХ, Засаг даргын зүгээс эдийн засгийн хөгжилд концессын бүх хэлбэрүүдийг дэмжих.
12. Үйлдвэрлэл, бизнесийн чиглэлийн гадаад, дотоодын төрийн бус болон төсөл хөтөлбөрийн байгууллагуудыг дэмжих.

Хүрэх үр дүн: Аймгийн эдийн засгийн хөгжил нэгдмэл бодлого-чөлөөт өрсөлдөөнд хөгжих нөхцлийг бүрдүүлсэн байна.

Дөрөв. Хугацаа

1. Энэхүү хөтөлбөр нь 2017-2020 оны I үе шатанд 70 хувь, 2021-2024 оны II үе шатанд 30 хувийг хэрэгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр байна.

Зургаа. Удирдлага, зохион байгуулалт

1. Тус хөтөлбөрийн үйл ажиллагаанд бүх салбарын оролцоог хангах, хамтын ажиллагааг зохицуулах үүргийг аймгийн Засаг даргын тамгын газар хариуцна.
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг аймгийн Засаг даргын тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь бусад хэлтэс албад болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагуудын хүчийг нэгтгэн зохион байгуулах замаар гүйцэтгэнэ.
3. Орон нутгийн түвшинд зохион байгуулсан ажлын явц, үр дүнг аймгийн Засаг даргын дэргэдэх холбогдох агентлагууд аймгийн Засаг даргын тамгын газарт хагас жил тутам тайлагнана.
4. Аймгийн засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, хөтөлбөрийн хүрээнд аймгийн хэмжээнд зохион байгуулсан ажлын явц, үр дүнг нэгтгэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд жил бүр тайлагнаж, хэвлэлээр олон нийтэд мэдээлнэ.
5. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээнд аймгийн төсөвт жил бүр хөрөнгө тусгана.

----ooOoo----